



П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ
УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/303

Улаанбаатар хот

Улсын гуравдугаар төв эмнэлгийн хүний нөөцийн,
хөгжлийн хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7.2, 16.7.3, Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.6, 21 дүгээр зүйлийн 21.3.1, Урт хугацааны хөгжлийн бодлого – “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Гурван тулгуурт хөгжлийн бодлого, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/103 дугаар тушаал, Эмнэлгийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.1, 4.10.4, 4.10.5, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.4, 2.7.3, 2.7.7, 3 дугаар зүйлийн 3.2.2, 3.2.14, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын гуравдугаар төв эмнэлгийн хүний нөөцийн хөгжлийг тогтвортой хангах зорилгоор Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр (2022-2025)-ийг нэгдүгээр, хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалийг хэрэгжүүлэхэд удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (С.Наранцэцэг), Эрдэм шинжилгээ, сургалт, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (О.Батгэрэл) нарт тус тус даалгасугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамтран гүйцэтгэх ажлын чиглэл тус бүрт дэмжлэг үзүүлж, холбогдох тасаг, төв, албадын албан тушаалтнуудыг үүрэгжүүлэн ажиллахыг нийт тасаг төв албадын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
4. Хөтөлбөрийн санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгах, бусад эх үүсвэрээс бүрдүүлэхийг Санхүү бүртгэлийн албаны дарга (Х.Алтантуяа)-д зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанар, аюулгүй байдлын албаны дарга (Б.Одончимэг), дотоод аудитор (Ц.Сугармаа) нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Ц.ТӨМӨР-ОЧИР

П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв
эмнэлгийн захирлын 2021 оны 12 сарын 31-ны
өдрийн 1/303-р тушаалын нэгдүгээр хавсралт

**УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН
ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР (2022-2025)**

Нэг. Нийтлэг үндэслэл

Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн лавлагаа шатны эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй, чанартай, хүртээмжтэй хүргэх эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ур чадварыг байнга хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулах, дэмжих шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Улсын гуравдугаар төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 05 дугаар тогтоолоор баталсан бүтцийн дагуу 2021 оны 4-р улирлын байдлаар нийт 810 ажилтантайгаас эмч 192/ 24%, сувилагч, тусгай мэргэжилтэн 377/ 46%, эмнэлгийн бусад ажилтан 242/ 29%, туслах ажилтан тус тус ажиллаж, нийт ажилтнуудын 692/ 85%, нь эмэгтэйчүүд байна.

Нийт ажилтны 06 буюу 14.3% нь гэрт, 167 буюу 22.5% нь хашаа байшинд, 453 буюу 61,13% нь орон сууцанд, 14 буюу 1.9% нь нийтийн байранд, 1 хүн зориулалтын бус байранд тус тус амьдарч байна.

Ажилтнуудын 588 буюу 79.3 % нь өөрийн эзэмшилд буй орон байранд амьдарч байгаагаас гэрт 81, орон сууцанд 369, хашаа байшинд 138 ажилтан тус тус амьдарч байна. Түрээсийн орон байранд 86 ажилтан буюу 11.6% нь (орон сууц 56, хашаа байшин 6, гэр 10, нийтийн байр 13, зориулалтын бус 1) амьдарч байна. Айлд 67 буюу 9% нь амьдарч байна. Үүнээс айлын гэрт 16, айлын хашаа байшинд 23, айлын орон сууцанд 27, нийтийн байранд 1 ажилтан байна.

Өрх толгойлсон нийт 88 буюу 11,87%, үүнээс эмэгтэй 87, эрэгтэй 1. Эдгээр өрх толгойлсон 88 ажилтны амьдрах орон байрны бэрхшээлтэй 27 буюу 30,6% байна. Үүнээс 16 ажилтан түрээсээр (2 нь гэр, 3 нь нийтийн байр, 11 нь орон сууц), 11 ажилтан айлд тус тус тус амьдарч байна.

Нийт ажилтны 79.2% нь ямар нэг зээлтэй, үүнээс орон сууцны ипотекийн зээлтэй 74 буюу 12,6% эзэлж байна.

Засгийн газрын ажлын байрны үнэлгээнд суурилсан цалингийн тогтолцоог 2018 оноос нэвтрүүлсэн хэдий ч эрүүл мэндийн ажилтнуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх шаардлага байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эмнэлгийн

ажилтнуудын нийгмийн хамгааллын чиглэлээр өнөөгийн түвшинд хүрсэн эерэг үр дүнг хадгалах, цаашид сайжруулах зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулаа.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

- 2.1.1 ил тод байх;
- 2.1.2 ажилтнуудын санаачилгад тулгуурлах;
- 2.1.3 хамтын ажиллагаа, дэмжлэгт түшиглэх.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Эмнэлгийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулж, тасралтгүй хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хөгжүүлэх, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн чадварлаг мэргэжилтнүүдийг татан ажиллуулах зэрэг замаар хүчирхэг хүний нөөцийг бүрдүүлэх, сэтгэл ханамжийг нь нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

4.1 Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

- 4.1.1 Эмнэлгийн ажилтнуудын ажлын орчинг сайжруулж, эрүүл мэндийг хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 4.1.2 Эрүүл мэндийн ажилтныг ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг сайжруулах;
- 4.1.3 Мөнгөн болон мөнгөн бус урамшууллын шинэ аргыг нэвтрүүлж, ажилтны бодит орлогыг нэмэгдүүлэх;
- 4.1.4 Нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах явцыг нэмэгдүүлэх

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1 эмнэлгийн ажилтны аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаалах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 5.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг тогтмол хугацаанд холбогдох талуудтай хамтран хагас жил тутамд үнэлэх;
- 5.1.2 Ажилтнуудын дунд мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн судалгааг тогтмол хийж, хариу арга хэмжээ авах
- 5.1.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлийн сургалт, сурталчилгааг ажилтнуудад тогтмол зохион байгуулах;
- 5.1.4 Ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хагас жил тутамд хамруулах, хяналтанд авах, эмчлэн эрүүлжүүлэх;
- 5.1.5 Ажилтнуудад ажлын байранд сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ авах боломжоор хангах;

5.2 Эмнэлгийн ажилтныг ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг сайжруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 5.2.1 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг үе шаттайгаар ажлын байран дээрхи болон зайн, танхимийн хэлбэрээр төгсөлтийн дараахь сургалтанд тогтмол хамруулах;
- 5.2.2 олон улсын төсөл, хөтөлбөр, байгууллагын санхүүжилтээр болон гадаадын байгууллагуудтай түншлэлийг нэмэгдүүлэх замаар өндөр хөгжилтэй оронд эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах тоог нэмэгдүүлэх;
- 5.2.3 Шинэ ажилтныг хамт олонд танилцуулах, ажлын байранд дадлагажуулах сургалтыг боловсронгуй болгон, өргөжүүлэх;

5.3 Мөнгөн болон мөнгөн бус урамшууллын шинэ аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн ажилтны бодит орлогыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 5.3.1 Эмнэлгийн ажилтны ажлын ачааллын тооцон мэргэжил бүрээр гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг шинэчлэн хэрэгжүүлж, үр дүнг тооцон мөнгөн болон мөнгөн бус урамшууллын тогтолцооны шинэ загварыг хэрэгжүүлэх;
- 5.3.2 Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогын тодорхой хувийг тухайн тусламж, үйлчилгээг үзүүлсэн эмч, мэргэжилтнүүд болон багт олгох журмыг шинэчлэн хэрэгжүүлэх;
- 5.3.3 Эмнэлгийн ажилтнуудын орон сууцны нөхцөлийг сайжруулах чиглэлээр төрийн болон төрийн бус холбогдох байгууллагатай амтран ажиллаж, залуу эмч, ажилчдыг орон сууцжуулах ажлыг зохион байгуулах;
- 5.3.4 Зээл авах хэрэгцээтэй эмнэлгийн ажилтанд бага хүүтэй цалингийн болон хэрэглээний зээл олгоход банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах;
- 5.3.5 Эмнэлгийн ажилчдын чөлөөт цагт зориулсан спорт заал, иогийн танхим, спортын талбай зэрэг байгууламжийг бий болгон, ажиллуулах;
- 5.3.6 Эмнэлгийн ажилчдад зориулсан хүүхдийн байгууллагатай болох (цэцэрлэг, ясли, өндөр өнжүүлэх г.м).

5.4 Хүний нөөцийн аливаа үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, (мэдээний сан -сургалт, хөгжил, нийгмийн халамжийн үйл ажиллагаа г.м).

Зургаа. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

6.1. Хөтөлбөрийг 2022-2025 онд хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр үндэсний хэмжээнд лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг бүрэн хэрэгжүүлэх мэдлэг чадвар бүхий хүний нөөцийн багийг бүрдүүлнэ. Эмнэлгийн ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллан, эрүүл мэндийн хамгаалал, нийгмийн баталгааг дэмжсэнээр эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал, чанар хүртээмж нэмэгдэнэ.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

8.1 Хөтөлбөрийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 8.1.1 Байгууллагын зардал;
- 8.1.2 Олон улсын байгууллагын тусламж;
- 8.1.3 Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив;
- 8.1.4 Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Ес. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ жил бүр хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг мэргэжлийн нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулна.

9.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн I улиралд багтаан Удирдах зөвлөлийн хуралд танилцуулна.

-----o0o-----

Улсын Гурвалдугаар төв эмнэлгийн захирлын
2021 оны 12 сарын 31-ны өдрийн /2021/ 308
Угшаалын хоёрдугаар хавсралт

УЛСЫН АНГАДТАР ХОТ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (2022-2025)

ЭМНЭЛГИЙН
ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТЫН
ХҮРЭЭНД

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (2022-2025)

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Эхлэх түвшин	Хүрэх түвшин	Хугацаа (он)					Санхүүжилт
				2022	2023	2024	2025		
Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах нэгдүгээр зорилтын хүрээнд									
1.	Эмнэлгийн хүний нөөцийн нийгмийн батлгааны хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх	2021 оны үзүүлэлт	Судалгааны тайлан, зөвлөмжид тулгуурлан хийгдсэн үйл ажиллагааны тоо						Судлаачдын багаар гүйцэтгүүлэх
2.	Эмнэлгийн 2024 он хүртэлх хүний нөөцийн орон тооны хэрэгцээг тодорхойлох	2021 оны үзүүлэлт	Судалгааны тайлан, зөвлөмжинд суурилсан үйл ажиллагааны тоо						Судлаачдын багаар гүйцэтгүүлэх
3.	Байгууллага хөгжлийн хэтийн төлөвт суурилсан карьерын хөгжлийн тогтолцоог тодорхойлж, хэрэгжилтийг хангах		Батлагдсан хөгжлийн баримт бичиг						Дотоод нөөц
4.	Хүний нөөцийн мэдээ, мэдээллийг цахимжуулах		Хүний нөөцийн цахим мэдээний сан						Дотоод нөөц
Эмнэлгийн ажилтны аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаалах хоёрдугаар зорилтын хүрээнд:									
5.	Тасаг, нэгж бүрт ажлын байрыг стандартын дагуу тохижуулах	2021 оны түвшин	Стандартын шаардлага хангасан ажлын орчинг бүрдүүлсэн байна.						Дотоод нөөц
6.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг тогтмол хугацаанд холбогдох талуудтай хамтран үнэлж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх	2021 оны түвшин	- ХАБ-ын нөхцөл сайжирсан. - Орон тооны чадварлаг мэргэжилтнээр хангагдсан байна.						Дотоод нөөц

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Эхлэх түвшин	Хүрэх түвшин	Хугацаа (он)				Санхүүжилт
				2022	2023	2024	2025	
7.	Ажилтнуудын дунд мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн судалгааг хийж, хариу арга хэмжээ авах тогтолцоог бүрдүүлэх	2021 оны түвшин	Дүрэм, журмыг шинэчлэн мөрдүүлсэн байна					Дотоод нөөц
8.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлийн сургалт, сурталчилгааг тогтмолжуулах	2021 он түвшин	ХАБ мэдлэг хандлага сайжирсан байна.					Дотоод нөөц
9.	Ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хагас жил тутамд хамруулах, хяналтанд авах, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулах	2021 он түвшин	Ажилтнуудын эрүүл мэндийн хяналт тогтмолжин, ажлын бүтээмж дээшилнэ.					Дотоод нөөц
10.	Ажилтнуудад ажлын байранд сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээг бий болгох	2021 он түвшин	Мэргэжлийн эмч, зориулалтын танхимтай болсон байна.					Дотоод нөөц
11.	Мөнгөн ба мөнгөн бус урамшуулалын шинэлэг тогтолцоог нэвтрүүлж урамшууллыг ажлын гүйцэтгэлийг сайжруулах хөшүүрэг болгох	2021 он түвшин	Ур дүнд суурилсан олон төрлийн урамшууллын механизмг бий болгосон байна					Дотоод нөөц
12.	Чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх спорт заал байгуулах, бусад нөхцөлийг бий болгох	2021 он түвшин	Эмч, ажилтнуудад зориулсан спортын байгууламжтай болсон байна.	төсө л	эхлү үлэх	дуус гах		, гадны санхүүжилт
13.	Эмнэлгийн ажилчдын хүүхдийн цэцэрлэг байгуулж, өндөр өнжүүлэх бүлгэм ажиглуулах	2021 он түвшин	Заалу ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж сайжирна.	төсө л	эхлү үлэх	дуус гах		Гадны эх үүсвэр
Эмнэлгийн ажилтныг ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг сайжруулах гуравдугаар зорилтын хүрээнд								
14.	Эмнэлгийн мэргэжилтний сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2021 оны түвшин	Шинэчилсэн сургалтын хөтөлбөр					Дотоод нөөц
15.	Эмнэлгийн эмч ажиллагсдын мэргэжлийн үнэлгээ чадамжийг мэргэжлийн онцлогт тохирсон шалгуураар тодорхойлох аргачлалыг нэвтрүүлнэ.	2021 оны түвшин	Мэргэжлийн онцлогт тохирсон ур чадвар, мэдлэгийн үнэлгээтэй болно.					
16.	Эмч, ажиллагсдыг төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтанд хамруулалтыг жил	2021 оны түвшин	5 % хамрагдсан байна					Дотоод нөөц,

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Эхлэх түвшин	Хүрэх түвшин	Хугацаа (он)				Санхүүжилт
				2022	2023	2024	2025	
	бүр 5%-иар нэмэгдүүлэх							Төрийн сан
17.	Эмч нарыг нарийн мэргэжлийн сургалтанд хамрагдалтыг жилд 3-5%-иар нэмэгдүүлэх	2021 оны түвшин	Эмч нарын мэргэжлийн ур чадвар дээшилнэ.					Дотоод нөөц, Төрийн сан
18.	Эмч мэргэжилтнүүдийг гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад сургаж бэлтгэх	2021 оны түвшин	Тусламж, үйлчилгээний чанар сайжирна					Дотоод нөөц, Төрийн сан Донор байгууллага уд
19.	Эмч, мэргэжилтнүүдийг ажлын байран дээрх дагалдан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	2021 оны үзүүлэлт	Мэргэжилтнүүдийн тасралтгүй хөгжил хангагдана.					